

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг.Макро эдийн засаг

Төсөв санхүү

Аймгийн төсөвт 3500.8 сая. төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 125.0 хувиар биелэсэн ба нийт орлогын 99.0 хувийг урсгал орлого эзэлж байна.Төсөвт газруудын өөрийн орлогын төлөвлөгөө 13.1 хувиар биелж 60.0 сая.төгрөгт хүрсэн байна.

Улсын төвлөрсөн төсөв болон орон нутгийн төсвөөс 24810.9 сая. төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 5.0 хувийг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд, 50.0 хувийг цалин хөлсөнд, 38.0 хувийг бараа үйлчилгээний зардалд, 7.0 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Төсвийн байгууллагуудын дүнгээр 8.3 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Өр үүсээгүй байна.

Ажил эрхлэлт ба ажилгүйдэл

Манай аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 68629 хүн байгаагаас 49876 ажиллагсад, ХЭАлбанд бүртгэлтэй ажилгүйчүүд 2115, бүртгэлгүй ажил эрхлээгүй хүн ам 5618, суралцагсад 6963, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам 4057 байна.Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл : нийт ажиллагсадын 65.0 хувь нь ХАА-н салбарт, 9.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдаанд,10.0 хувь нь төрийн байгууллагад, 16.0 хувь нь бусад салбаруудад ажиллагсад эзэлж байна. .Ажиллагсадын тоо өмнөх оныхоос 1.0 хувиар өссөн байна.Эдийн засгийн идэвхитэй хүн ам болон ажиллагсадын дотор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа бол бүртгэлтэй ажилгүйчүүдийн дүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй илүү байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст 2115 хүн бүртгэлтэй байгаагийн 57.0 хувь нь эмэгтэйчүүд байна.Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 33.0 хувь нь 25-34 насныхан, 29.0 хувь нь 35-44 насныхан, 25.0 хувь нь 16-24 насныхан, 13.0 хувь нь 45-60 насныхан байгаа ба 65.0 хувь нь урьд нь ажил эрхэлж байсан, 35.0 хувь нь анх удаа ажил эрж байгаа хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 37.0 хувь нь бүрэн дунд, 14.0 хувь нь дээд, 30.0 хувь нь бүрэн бус дунд, 5.0 хувь нь тусгай дунд, 8.0 хувь нь мэргэжлийн анхан шатны, 5.0 хувь нь бага боловсролтой байна.

Энэ онд аймгийн хэмжээнд 1939 байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

Ажлын байраар хангагдагсдын 15.0 хувь нь барилгад, 13.0 хувь нь хөдөө аж ахуйд,6.0 хувь нь үйлдвэрлэлд, 3.0 хувь нь зочид буудал зоогийн газарт,33.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдаанд , 4.0 хувь нь тээвэр, холбоонд,6.0 хувь нь уул уурхайд, 17.0 төсөвт байгууллага болон хувийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд ажлын байртай болжээ.

Үнэ

2008 оны эцсийн байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс 2007 оныхоос 12.8 хувиар өсч , өмнөх 11 сартай харьцуулахад 0.4 хувиар буурсан байна.

Өрхийн хэрэглээний 40.0 гаруй хувийг эзэлдэг хүнсний барааны үнийн өсөлт нь үнийн ерөнхий өсөлтөд шууд нөлөөлдөг. Өмнөх оны 12-р сартай энэ оныг харьцуулахад хүнсний барааны бүлгийн индекс 18.8 хувиар, гутал бөс бараанд 0.6 хувиар, орон сууцанд 9.8 хувиар, гэр ахуйн бараанд 0.2 хувиар, эм тариа эмнэлгийн үйлчилгээнд 32.9 хувиар, соёл боловсролын үйлчилгээнд 48.9 хувиар, бусад бараанд 7.8 хувиар нэмэгдсэн байна.Хэрэглээний үнэ өсөхөд оны эхний хагаст бензин шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор бүх бараа,үйлчилгээний үнэ нэмэгдсэнтэй холбоотой. Оны сүүлийн хагаст бензин шатахууны үнэ буурсан хэдий чбараа,үйлчилгээний үнэ хүрсэн түвшингээс буураагүй байна.

Банк, мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 1058.0 тэрбум төгрөгийг гүйлгээнээс татаж, 1070.7 тэрбум төгрөгийг гүйлгээнд гаргасан байна. Өнгөрсөн оноос гүйлгээнээс татсан төгрөгийн хэмжээ болон гүйлгээнд гаргасан төгрөгийн хэмжээ 1.0 хувиар тус тус буурсан байна.

Иргэд, байгууллагын мөнгөн хадгаламж 12.3 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дунджаар 111628 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 320800 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оноос хадгаламж 11.0 хувиар буурч, хадгаламж эзэмшигчийн тоо 21.0 хувиар өсчээ.

Арилжааны банкуудын дүнгээр 72871 иргэд, аж ахуйн нэгжид 64.7 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оноос зээлжигч 14.0 хувиар, олгосон зээлийн хэмжээ 4.0 хувиар нэмэгджээ. Оны эцэст зээлийн өрийн үлдэгдэл 38.5 тэрбум төгрөг байгаа ба хугацаа хэтэрсэн зээл 0.8 хувь буюу 310.8 сая.төгрөг, чааргүй зээл 0.3 хувь буюу 63.3 сая.төгрөг байна.

Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү 6.0-8.4 хувь, хугацаатай хадгаламжийн жилийн хүү 9.6-19.7 хувьтай байсан байна.

Хоёр. Нийгмийн үзүүлэлт

Хүн ам

Өвөрхангай аймгийн суурин хүн амын тоо жилийн эцсийн байдлаар 110.4 мянга болж өмнөх оныхоос 1.0 хувь буюу 991 хүнээр өссөн байна. Нийт хүн амын 49.0 хувь нь эрэгтэйчүүд, 51.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 100 эмэгтэйд 97.3 эрэгтэй ногдож байна.

Өрх 30.7 мянгад хүрч, өнгөрсөн оноос 3.0 хувь буюу 1012 өрхөөр нэмэгджээ. Нийт хүн амын 32.0 хувийг 0-15 насны хүүхэд, 62.0 хувийг 15-59 насны, 6.0 хувийг 60 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. 100 ба түүнээс дээш настай хүн 3 байна. Эдгээр нь эмэгтэй байна.

Аймгийн нийт өрхийн 20.0 хувь нь аймгийн төвд, 25.0 хувь нь сумын төвд, 55.0 хувь нь хөдөөд, нийт хүн амын 11.0 хувь нь аймгийн төвд, 14.0 хувь нь сумдын төвд, 52.0 хувь нь хөдөө суурьшсан байна.

Хүн амын ердийн хөдөлгөөн

Төрсөн 2702 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 680 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 1218 хос гэрлэлтээ бүртгүүлж, 14 гэр бүл гэрлэлтийг цуцалж, 122 хүүхэд үрчлэгдсэн байна.

Бүртгүүлсэн гэр бүлийн 71.0 хувь тайлант онд гэрлэжээ. Гэрлэсэн эрэгтэйчүүдийн 53.0 хувь нь 20-24 насныхан, 29.0 хувь нь 25-29 насныхан, 3.0 хувь нь 18-19 насныхан эмэгтэйчүүдийн 53.0 хувь нь 20-24 насныхан, 14.0 хувь нь 18-19 насныхан байна.

Нийт гэр бүл цуцлалтын 36.0 хувь 10-14 жил гэр бүл байсан, үрчлэлтийн 37.0 хувь 3 хүртэл насны хүүхэд байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөн

Энэ онд тус аймгаас Улаанбаатар болон бусад аймгуудад 1637 хүн шилжин явж, тэдгээрээс 635 хүн шилжин иржээ. Шилжин явагсдын 85.0 хувь нь Улаанбаатар хот руу шилжин явсны 92.0 хувь нь 15-54 насныхан байна.

Сүүлийн 5 жилд шилжин ирэгсдээсээ шилжин явсан хүний тоо их байгаа бөгөөд 2008 оны байдлаар шилжих хөдөлгөөн 2.5 х1 харьцаатай байна.

Хүн амын эмзэг бүлэг

Сумдуудын өөрсдийнх нь тодорхойлж ирүүлсэн мэдээгээр амьжиргааны баталгаажих доод төвшнөөс доогуур орлоготой 6985 өрхөд 26.5 мянган хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 22.7, нийт хүн амын 24.0 хувийг тус тус эзэлж байна.

Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой өрхийн 36.0 хувь нь нэн ядуу өрх байна.

2008 оны байдлаар Хангайн бүсийн хэмжээнд амьжиргааны баталгаажих доод түвшин 85100 төгрөг байна.

Аймгийн хэмжээнд 199 бүтэн өнчин, 1912 хагас өнчин хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 2065, өрх толгойлсон эмэгтэйчүүд 2759 байна. Нийт өрхийн 9.0 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

Нийгмийн халамж, даатгал

Нийгмийн халамжийн тэтгэмж, тусламж авсан хүний тоо 75905 болж өмнөх оныхоос 2.0 хувиар нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн зардал 9.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 77.0 хувь буюу 4.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр авдаг 2047 хүнд 884.3 сая. төгрөг олгожээ.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хүрээнд 2008 онд 45.3 мянган хүүхэдэд 5.7 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон нь 2007 онтой харьцуулахад хүүхдийн тоо 800-аар, олгосон тэтгэмжийн хэмжээ 4.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт төрөөс 100.0 мянган төгрөгийн тэтгэмжийг жилд нэг удаа олгож байна. Энэ арга хэмжээнд 2746 хүүхэдэд 274.6 сая. төгрөгийг зарцуулсан нь өмнөх оныхоос хүүхдийн тоо 168-аар нэмэгдсэн байна. Анх удаа гэрлэгчдэд олгох 500.0 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг 1173 гэрлэсэн хосод олгож, нийт 586.5 сая. төгрөгийг зарцуулав.

Түүнчлэн “Үдийн цай хөтөлбөрт 2007-2008 оны хичээлийн жилд 10.7 мянган сурагчдыг хамруулж, улсын төсвөөс 751.0 сая. төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 13.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 102.7 хувиар биелэн өнгөрсөн оноос сангийн нийт орлого 23.0 хувиар нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сайн дурын орлого 49.5 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 86.7 хувь, эрүүл мэндийн даатгалын хураамж 60.6 хувь, тус тус биелжээ. Бүх төрлийн тэтгэвэр авагч 13542 хүнд 12.9 тэр. бум төгрөгийн тэтгэвэр 1750 хүнд 278.4 сая. төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Боловсрол

2008-2009 оны хичээлийн жилд 28 сургуулийн 748 бүлэгт 24307 хүүхэд суралцаж байна, Суралцагчдаас 58 бүлэгт 1690 сурагч 12 жилийн хөтөлбөрөөр хичээллэж байна. Нийт суралцагчдын 42.0 хувь нь малчдын хүүхэд байна. Бүтэн өнчин 138, хөгжлийн бэрхшээлтэй 967 сурагч байна.

Сургуулийн өмнөх боловсролын 30 байгууллагын 165 бүлэгт 5.2 мянган хүүхэд хамрагдаж байгаагаас цэцэрлэгийн 106 бүлэгт 2.8 мянган хүүхэд хүмүүжиж байна. ЕБСургуульд 1632 багш ажилчид, СӨБ-д 262 багш ажиллагсад ажиллаж байна.

Нэг ангид ногдох хүүхдийн тоо 32 байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 2 пунктээр багассан байна.

Сургуулиудын 28 дотуур байранд 2811 хүүхэд амьдарч байгаагийн 96.0 хувь нь малчдын хүүхэд байна. Байрны байранд ажиллагсадын тоо 221 байгаагийн 33 нь багш бусад нь ажилчид байна.

Аймгийн 2 Их сургуульд 731 оюутан, 919 сурагч суралцаж байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагуудад 2008 оны байдлаар 185 их эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн 528, эм зүйч 9 ажиллаж 1 их эмчид 597 хүн, дунд мэргэжилтэнд 209 хүн, ногдож байна. Эмнэлгийн орны тоо 631 өмнөх оныхоос 0.8 хувиар нэмэгдсэн байна. мэдээгээр

аймгийн хэмжээнд 2718 хүүхэд төрж, 624 хүн нас барж өнгөрсөн оноос төрөлт 14.0 хувиар нэмэгдэж , нас баралт 1.0 хувиар буурсан байна. Нас баралтын 13.0 хувийг нялхсын нас баралт эзэлж байгаа ба энэ нь өнгөрсөн оноос 1.5 хувиар буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 24.6 , нас баралт 5.7 байна. Төрөхийн улмаас 1 эх эндсэн байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 1413 тохиолдол гарсан нь өнгөрсөн оноос 29.0 хувиар буурсан байна. Нийт өвчлөлтийн 23.0 хувийг халдварт шар, 3.0 хувийг сүрьеэ, 20.0 хувийг заг хүйтнээр өвчлөгсөд эзэлж байна.

Соёл урлаг

Номын сан 66.2 мянган ширхэг хөмрөгийн номтой ба 9.2 мянган хүнд 30.0 мянган ширхэг ном олгон уншуулж үйлчилжээ. 2007 онд 4.5 мян.төгрөгийн 948 номоор номын фондоо баяжуулсан байна.

Музейн үзмэрээс онцгой үзмэр 15 буюу 0.4 хувийг эзэлж байна. Үзмэрээс 542.0 мян.төгрөгийн орлого олж өнгөрсөн оноос 8.0 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн ХДТеатр 14 удаа тоглолт хийн, 6860 хүнд тоглолтоо толилуулан, 2744.4 мян. төгрөгийн орлоготой ажиллажээ.

Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 375 хэрэг бүртгэгдэж өнгөрсөн онтой ,харьцуулахад 31.0 хувиар буурсан байна.Гарсан хэргийн илрүүлэлт 67.0 хувьтай байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 17.0 хувь нь хүнд, онц хүнд хэрэг, 38.0 хувь нь хөнгөн хэрэг,45.0 хувь нь хүндэвтэр хэрэг эзэлж байна. Гэмт хэрэг үйлдсэн 410 хүн байгаанийн 30.0 хувь нь согтуугаар ,21.0 хувь нь бүлэглэн үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл: нийт хэргийн 38.0 хувийг хулгайн хэрэг, 29.0 хувийг иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг, 8.0 хувийг танхай, 2.0 хувийг дээрмийн хэрэг, 10.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг, 3.0 хувийг хүчингийн хэрэг, 2.0 хувийг хүн амины хэрэг, 1.0 хувийг ашиглан шамшигдуулах хэрэг,7.0 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оноос хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг 10.0 хувиар, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 29.0 хувиар, булаалт дээрмийн 42.0 хувиар, залилан дээрмийн хэрэг 25.0 хувиар, иргэдийн орон байрны хулгай 34.0 хувиар өсч, иргэдийн малын хулгай 22.0 хувиар , бусад хэргийн гаралт 37.0 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 182.2 сая төгрөгийн хохирол учирч, 96 хүн нас барж, 176 хүн хүнд хөнгөнөөр гэмтсэн ба нийт хохирлын 86.0 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон 410 хүний 42.0 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 38.0 хувь нь малчин,5.0 хувь нь албан хаагч,3.0 хувь нь сурагч,10.0 хувь нь ажилчин,2.0 хувь нь оюутан

Хэв журмын нөхцөл байдлын хувьд 1343 мянган хүн эрүүлжигдэн, 194 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдаж, хутга мэстэй холбоотой 258 зерчил гарч, өнгөрсөн оноос эрүүлжүүлэгдсэн хүний тоо 54.0 хувиар , баривчлагдсан хүний тоо 25.0 хувиар буурсан байна.

Нийт 2177 тээврийн хэрэгслэлийг журамлаж,согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 152 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ.

Гурав. Үйлдвэрлэл үйлчилгээний салбар.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 3487.4 сая. төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, оны үнээр 3341.7 төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос үйлдвэрлэлт 32.8 хувиар, борлуулалт 27.6 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 31.9 хувийг хүнсний салбарт, 20.8 хувийг цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт, 23.0 хувийг мод модон эдлэлийн үйлдвэрлэлт

14.2 хувийг уул уурхайн салбарт, 10.1 хувийг бусад жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлийн салбаруудад тус тус үйлдвэрлэжээ.Өнгөрсөн онтой харьцуулахад дээрхи салбаруудын үйлдвэрлэлт 0.2-3.5 дахин хувиар өссөн байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 70.1 хувийг талх, нарийн боов , 21.6 хувийг архи , 2.5 хувийг ундаа,1.4 хувийг тараг,3.6 хувийг ааруул,0.2 хувийг цэвэр ус,зайрмаг үйлдвэрлэлт тус тус эзэлж байна.

Хөдөө аж ахуй

Манай аймгийн эдийн засгийн гол үндэс болсон бэлчээрийн мал ажуйн салбар нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэд гол байр суурь эзэлсэн хэвээр байна.Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 70.0 гаруй хувийг ХАА-н салбарт үйлдвэрлэж,үүний 96.0 хувийг мал аж ахуйн салбар эзэлж байна.

Малын 2008 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 3449.7 мянган толгойд хүрч өссөний дотор тэмээний тоо 14.1 мянга,адуу 172.9 мянга,үхэр 134.7 мянга, хонь 1569.2 мянга,ямаа 1558.6 мянга болж тэмээ 576 толгойгоор,үхэр 1296 толгой, хонь 107.0 мянга толгойгоор,ямаа 152.5 мянган толгойгоор нэмэгдэж , адуу 1966 толгойгоор буурсан байна..

Аймгийн дүнгээр 20062 малтай өрх, үүнээс 17015 нь малчин өрх байна. Эдгээр өрхийн тоо 2006 оныхоос малтай өрх 0.5 хувиар, малчин өрх 2.6 хувиар өссөн байна. Аймгийн нэг малтай өрхөд 172, нэг малчин өрхөд 202.7 толгой мал ноогдож байна.

Аймгийн хэмжээнд 1000 ба түүнээс дээш малтай 201 өрх байгаа нь өмнөх оныхоос 23.0 хувиар нэмэгдсэн байна.

Оны эхний малын 181.7 мянган малыг зах зээлд худалдан борлуулж, 270.6 мянган малыг хүнсэнд хэрэглэж, 266.2 мянгыг бусдад шилжүүлсэн байна.

1397.7 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 41.0 хувийг эзэлж , өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 12.0 хувиар буюу 145.9 толгойгоор өсч нийт малд эзлэх хувийн жин 2.0 пунктээр өссөн байна.

41050 толгой хээлтүүлэгчийн 77.0 хувийг хуц, ухна эзэлж байна. Нэг хээлтүүлэгчид 23 ингэ , 7 гүү, 20 үнээ, 41 эм хонь, 41 эм ямаа ногдож байгаа нь үржлийн нормт хэмжээнээс ингэ, гүү доогуур, эм хонь, эм ямаа нормын түвшинд байна.

Аймгийн хэмжээнд аж ахуй нэгж байгууллагууд 6743 толгой мал тоолуулсан байна. Цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 282.0 мян. мал тоологдсоны 4.0 хувь буюу 10905 нь цэвэр үүлдэр, 96.0 хувь буюу 271115 нь эрлийз үүлдрийн мал байна.

Аймгийн дүнгээр 155 гахай, 3 илжиг, 378 тахиа тоологдож, өмнөх оноос гахайн тоо 29-өөр , тахиа 497-оор тус тус буурчээ.

Оны эхний төллөх эх малын 86.6 хувь буюу 1083.9 мянган эх мал төллөж гарсан төлийн 87.1 хувь буюу 949.0 мянган төлийг бойжуулсан байна.

Оны эхний нийт малын 4.3 хувь буюу 139646 толгой мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оноос 11.5 дахин их байна. Нийт хорогдлын 81.0 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 22.9 хувь буюу 2755 нь өвчнөөр хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд энэ онд шинээр 76 худаг гаргаж, 62 худаг засварласан байна.

Аймгийн дүнгээр хаврын тариалалтаар 570 га-д үр тариа, 241.0 га-д төмс, 122.9 га-д хүнсний ногоо тариалж, намрын ургац хураалтаар 470 га-аас 150 тн үр тариа , 234.7 га-аас 2230.7 тн төмс , 119.7 га-аас 1327 тн хүнсний ногоо хураан авчээ. Өнгөрсөн оноос үр тариа 145.6 тн-оор их, төмс 205.7 тн-оор , хүнсний ногоо 45.2 тн-оор тус тус их байна. Иргэд 38696.7 тн хадлан, 6852.4 тн гар тэжээл бэлтгэжээ.

Хөрөнгө оруулалт ,Барилга

Энэ онд аймгийн эдийн засаг,нийгмийн хөгжилд 9.8 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 6.1 тэрбум буюу 62.0 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр,792.3 сая.төгрөг буюу 8.0 хувь нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр , 180.6 сая. төгрөг буюу 2.0 хувь нь гадаадын хөрөнгөөр, 2.6 тэр бум төгрөг буюу 27.0 хувь нь иргэний өөрийн хөрөнгөөр хийгдсэн байна.

Тус аймагт 6.8 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 75 объектод хийж гүйцэтгэснээс 39.4 хувь нь их засварын ажил байна.

Тээвэр, холбоо

Сүүлийн жилүүдэд хувийн хэвшил авто тээврийн салбарт зонхилох үүрэгтэй болсон.Хот хоорондын болон орон нутгийн зорчигч болон ачаа тээврийн авто машин,таксины үйлчилгээг хувийн хэвшлийн гүйцэтгэж байна. Аймгийн дүнгээр 470 иргэн тээврийн үйлчилгээ явуулж давхардсан тоогоор 25.4 мян.тн ачаа тээвэрлэн, 10.6 мян. тн/км-ийн ачаа эргэлт, 160.2 мян. зорчигч тээвэрлэн, 40.1 мян хүн/ км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэж 920.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оноос тээврийн орлого 33.7 хувиар өсчээ.

Холбооны байгууллагууд 430.2 сая.төгрөгийн тарифын орлоготой ажилласны 30.6 хувийг хүн амын орлого эзэлж, өнгөрсөн оноос тарифын орлогын дүн 16.4 хувиар буурчээ.Аймгийн 1805 айл өрх, 498 аж ахуйн нэгж байгууллага телефон цэгтэй байгаа ба 4500 телевизийн цэг, 372 кабелийн цэг ашиглагдаж байна.Сүүлийн жилүүдэд үүрэн телефон хэрэглэгчийн тоо эрчимтэй өсч 2008 онд 29543 болж өмнөх оноос 43.4 хувиар өсчээ. Суурин телефон цэгийн тоо 2356 болж өнгөрсөн оныхоос 44-өөр цөөрсөн байна. Интернетээр үйлчлүүлэгчдийн тоо 2520-д хүрч өмнөх оноос 1.0 дахин өсч интернетийн үйлчилгээнээс 23.0 сая.төгрөг орсон нь өмнөх оныхоос 60.0 хувиар нэмэгдсэн байна.

Шуудан холбооны орлого 110.1 сая төгрөг болж өнгөрсөн оноос 26.8 хувиар өссөн байна.

Худалдаа, үйлчилгээ

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 7.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 16.5 хувиар өсчээ. Худалдаа нийтийн хоолны цэгийн тоо өмнөх оноос 42-оор нэмэгджээ.

Орон сууц

Энэ онд иргэдийн өөрийн хөрөнгөөр 12765.6 м.кв ашигтай талбай бүхий 236 хувийн өмчийн орон сууц ашиглалтанд оржээ. Эдгээр сууцанд 236 өрх буюу 912 хүн оршин сууж, амьдарч байна.

Үүнд: Сумдын иргэдийн амины зориулалтаар барьсан хувийн, энгийн галлагаатай байшингууд хамрагдсан болно.

Бусад мэдээлэл.

Аймгийн татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 865 байгаагийн төсөвт байгууллага -193, ХК 19, ХХК -330, салбарууд-94, хоршоо-83, ЗБН,ББН-83, төрийн бус байгууллага-23, ОНБайгууллага-14,хадгаламж зээлийн хоршоо -13,шашны байгууллага-7 байна.

Сүүлийн жилүүдэд уламжлалт буддын шашны сүм хийдүүд олноор байгуулагдан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 14 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрт 267 хүн ажилладгаас 212 нь хурлын лам нар байна.

Аймгийн хэмжээнд 2008 оны байдлаар 44 осол гамшиг тохиолдож 319.0 сая.төгрөгийн хохирол учирч, 18 хүн нас барсан байна.